



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 231

Улаанбаатар хот

Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Авлигатай тэмцэх газрын “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай” 2022 оны 05/6836 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Увс АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай.

1.1.Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 01/1838 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг үндэслэн Раднаагийн Төмөр-Чөдөрийг “Увс АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлаар томилох.

1.2.“Увс АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Р. Төмөр-Чөдөртэй Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг хууль тогтоомжийн дагуу байгуулж ажиллах.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



132001664